



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 626

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Замын-Үүдийн дулааны станц" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 10 нэрийн, нийт 225,806,540.73 (хоёр зуун хорин таван сая найман зуун зургаан мянга таван зуун дөчин төгрөг далан гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 87,520,725.25 (наян долоон сая таван зуун хорин мянга долоон зуун хорин таван төгрөг хорин таван мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Замын-Үүдийн дулааны станц" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал О.Төмөрхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006614
32-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

"ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ, хугацаа			
							Цаашид ашиглах жил	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Зөөврийн компьютер Dell i5	2018.06.30	1	ш	1,452,000.00	1,452,000.00	2	1	580,800.00	580,800.00
2	Зөөврийн компьютер Dell i3	2016.04.01	1	ш	1,600,000.00	1,600,000.00	2	1	640,000.00	640,000.00
3	Зөөврийн компьютер Dell i3	2017.08.31	1	ш	1,320,000.00	1,320,000.00	2	1	528,000.00	528,000.00
4	Зөөврийн компьютер Dell i3	2017.08.31	1	ш	1,815,000.00	1,815,000.00	2	1	726,000.00	726,000.00
5	Зөөврийн компьютер Dell i3	2014.04.01	1	ш	1,800,000.00	1,800,000.00	1	1	360,000.00	360,000.00
6	Проектор /PJ6241/	2021.08.27	1	ш	967,140.00	967,140.00	1	1	322,380.00	322,380.00
7	Мотоцикл /З дугуй/ ДГЗ 45-47	2017.01.09	1	ш	1,409,800.00	1,409,800.00	1	1	281,960.00	281,960.00
8	Ус түгээх шугам сүлжээ	1955.08.27	23460	м	3,776.00	88,584,960.00	2	23460	1,510.40	35,433,984.00
9	Дулааны шугам	1957.01.01	45747	м	2,544.00	116,380,368.00	2	45747	1,017.60	46,552,147.20
10	Авто худаг деспетчерийн программ	2018.01.01	1	ш	10,477,272.73	10,477,272.73	1	1	2,095,454.55	2,095,454.55
Нийт дүн			69215		20,847,532.73	225,806,540.73		69215	5,537,122.55	87,520,725.75
			(жаран есөн мянга хоёр зуун арван тав)		(хоёр зуун хорин таван сая найман зуун зургаан мянга таван зуун дөчин төгрөг далан гурван мөнгө)			(жаран есөн мянга хоёр зуун арван тав)		(наян долоон сая таван зуун хорин мянга долоон зуун хорин таван төгрөг далан таван мөнгө)